


МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БАТЛАВ:
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.СОРОНЗОНБОЛД

АЛСЫН ЗАЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Боловсруулсан:	Хянасан:
	
Д.Удвал	Д.Алтангэрэл

Энхтайвны өргөн чөлөө 46А
Улаанбаатар 211051, Монгол Улс
Утас: (976) 51 263907, (976) 51 263689
Факс: (976) 11 458032

Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ХЭВЛЭМЭЛ ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ БОЛНО.

ХЭВЛЭСЭН ОГНОО: 01.02.2021

ӨӨРЧЛӨЛТ NO: 01
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 01.02.2021

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн No	Хуудас No	Өөрчлөлт оруулсан шалтгаан
1	01	Бүхэлд нь	АРАС ТЕС 0-001, Итгэмжлэлийн байгууллага алсын зайн үнэлгээ хийх удирдамжид нийцүүлэн агуулгыг бүхэлд дахин хянаж найруулав.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 2/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

АГУУЛГА

Д/д	Бүлэг	Хуудас No.
	Өөрчлөлт оруулсан бүртгэл	2
	Өмнөх үг	4
1	Зорилго	5
2	Хамрах хүрээ	5
3.	Норматив эшлэл	4
4.	Нэр томьёо, тодорхойлолт	4
5.	Алсын зайн үнэлгээний хэрэглээ	6
6.	Алсын зайн үнэлгээний үйл явцад тавих шаардлага	6
	6.1 Дэд бүтцийн шаардлага	6
	6.2 Боловсон хүчний нөөц	8
	6.3 Нууцлал, аюулгүй байдал ба өгөгдлийг хамгаалах	8
7.	Алсын зайн үнэлгээг гүйцэтгэх	9
8.	Зайнаас үнэлгээ хийх бэлтгэл ажил	9
9.	Алсын зайн үнэлгээ	11
10.	Гэрчлэх үнэлгээний үйл явцын техник ажиллагаа	12

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS P706

Алсын зайн үнэлгээ хийх журам

Хэвлэсэн огноо: 01.02.2021

Өөрчлөлт No: 01

Өөрчлөлтийн огноо: 01.02.2021

Хуудас: 3/12

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өмнөх үг

Мэдээлэл харилцаа холбооны технологи улам боловсронгуй, дэвшилтэт болохын хэрээр үүнийг итгэмжлэлийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд хэрэглэх боломж нээгдэж байна.

Энэхүү технологийг итгэмжлэлийн үйл ажиллагаанд хэрэглэх тохиолдолд үнэлгээний үр дүнгийн бүрэн бүтэн байдал, нууцлалыг хангах шаардлагатай.

Энэ баримт бичиг нь алсын үнэлгээний төлөвлөлт, бэлтгэл ажил, удирдлага, гүйцэтгэлийн талаарх зааварчилгааг өгнө.

Алсын зайн үнэлгээ нь тохирлын үнэлгээний байгууллагын үнэлгээг хөнгөвчлөх нэмэлт үнэлгээний арга техникийг өгч болох бөгөөд энэ нь уламжлалт газар дээрх үнэлгээтэй харьцуулахад ижил ба түүнээс илүү өндөр үр дүнтэй байна.

Мөн алсын зайнаас үнэлэх арга техник нь ижил нөхцлөөр илүү олон байршил, чадавхийг гэрчилж, үнэлэх боломжийг олгоно.

Итгэмжлэлийн үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглах жишээнд дараах зүйлийг багтааж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй.

- Аудио, видео, өгөгдөл хуваалцах теле хурал;
- Алсын зайн хандалтыг ашиглан синхроноор (бодит цаг хугацаанд) эсхүл асинхроноор (боломжтой бол) баримт бичиг, бүртгэлийн үнэлгээ хийх;
- Зураг, видео эсхүл аудио бичлэг ашиглан мэдээлэл, нотлох баримтыг бүртгэх;
- Алслагдсан эсхүл аюултай байж болзошгүй байршилд виртуал/аудио нэвтрэх боломжийг олгох.

Зохицуулалтын шаардлага, оролцогч талуудын схем, норматив баримт бичиг, тохирлын үнэлгээний стандартууд нь үнэлгээнд мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглахад хязгаарлалт тогтоож, энэ баримт бичгээс давуу эрхтэй байж болно.

Алсын зайн үнэлгээ хийх журам

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 4/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

MNAS P706

1. Зорилго

Энэхүү журмын зорилго нь урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлаас шалтгаалан газар дээр нь үнэлгээ хийх боломжгүй тохиолдолд Үндэсний итгэмжлэлийн байгууллага (MNAS)-аас алсын зайн үнэлгээг хийх нийтлэг шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь дараах үнэлгээний үйл явцад хамаарна. Үүнд:

- давтан болон магадлах, дагалдах үнэлгээ,
- итгэмжлэлийн хүрээ өргөтгөх үнэлгээ (ноцтой биш, тусдаа чадавхи шаардахгүй итгэмжлэлийн хүрээний өргөтгөлүүд)
- баталгаат гарын үсэг зурагчийг батлах (урьдчилсан шаардлагыг хангах, хүлээн зөвшөөрөх, батлах);
- менежментийн тогтолцоог шалгах зорилгоор хийх мөшгөх үнэлгээ.

3. Норматив эшлэл

Энэхүү журамд дараах эш татсан баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)–ийг хэрэглэнэ. Үүнд:

- *APAC TEC 0-001, Итгэмжлэлийн байгууллага алсын зайн үнэлгээ хийх удирдамж;*
- *IAF/ILAC A2 IAF-ILAC, Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалт. Итгэмжлэлийн байгууллагыг үнэлэх шаардлага, журам;*
- *IAF MD 4:2018, Аудит, үнэлгээний зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах шаардлага;*
- *IAF MD 12:2012, Алсын зайн үнэлгээний зарчим.*

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1 Онцгой үйл явдал, нөхцөл байдал

Байгууллагын хяналтаас гадуур тохиолддог нөхцөл байдлыг ихэвчлэн "Давагдашгүй хүчин зүйл" гэж нэрлэдэг. Жишээ нь: дайн, ажил хаялт, үймээн самуун, улс төрийн тогтворгүй байдал, геополитикийн хурцадмал байдал, терроризм, гэмт хэрэг, тахал, тахал, үер, газар хөдлөлт, компьютерын хакердах, байгалийн болон гар аргаар үүссэн бусад гамшиг. (IAF ID 3: 2011-ыг үзнэ үү)

4.2 Алсын зайн үнэлгээ

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн Но: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт Но: 01	Хуудас: 5/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

МОНГОЛЫН УЛСЫН ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО

Цахим хэрэгслийг ашиглан тохирлын үнэлгээний байгууллагын бодит байршил эсвэл виртуал сайтад хийх үнэлгээг хэлнэ. Алсын үнэлгээнд онлайн хандалт, видео холбоос, веб хурал, утсаар ярилцлага хийх, баримт бичиг/бүртгэлийг дэлгэцийн үнэлгээ гэх мэт цахим хэрэгслээр хийсэн үнэлгээ орно. (ISO / IEC 17011: 2017, 3.26-г үзнэ үү)

ТАЙЛБАР 1: Виртуал сайт нь бусад хүмүүст үйл явцыг гүйцэтгэх боломжийг олгодог онлайн орчин юм.

5. Алсын зайн үнэлгээний хэрэглээ

5.1 Алсын зайн үнэлгээний хэрэглээг тодорхойлоход дараах нөхцөл байдал орох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй байж болно. Үүнд:

- a) Тохирлын үнэлгээний байгууллагад эсхүл тодорхой байршилд очих нь боломжийн бус/боломжгүй;
- b) Хямралын үед эсхүл хамгаалалт, эрүүл мэнд, аюулгүй байдалд үндэслэн Засгийн газар, зохицуулагч эрх бүхий байгууллагын өгсөн зааврын дагуу ТҮБ ба үнэлгээний газарт зочлох боломжгүй үед;
- c) Тодорхойлсон хугацаанд итгэмжлэлийн байгууллагын үнэлгээ хийх байгууллагын тоо олох байх тохиолдолд;
- d) Үнэлгээ хаана хийгдэж байгаагаас үл хамааран ТҮБ нь өгөгдөл, бүртгэлийг хянаж болох удирдлагын мэдээллийн системтэй байх тохиолдолд;
- e) Итгэмжлэлийн хамрах хүрээг бага зэрэг өөрчлөх үнэлгээний үед;
- f) ТҮБ нь тохирлын талаар батлагдсан бичлэг, нотлох баримттай үед;
- g) Итгэмжлэлийн байгууллага нь үнэлгээний эрсдэлийн төвшинг бага гэж үзэх үед;
- h) Газар дээрх үнэлгээг дуусгаж чадаагүй тохиолдолд газар дээрх үнэлгээг үргэлжлүүлэн хийх нь сайн шийдэл биш байх үед;
- i) Тухайлсан хугацаанд гүйцэтгэх боломжгүй байсан мөшгөх үнэлгээ шаардлагатай үед.

6. Алсын зайн үнэлгээний үйл явцад тавих шаардлага

6.1 Дэд бүтцийн шаардлага

6.1.1 Алсын зайнаас мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан Итгэмжлэлийн үнэлгээг амжилттай хийхэд хамгийн чухал хүчин зүйл нь тохиромжтой дэд бүтцийг бүрдүүлсэн байх шаардлага юм. Технологи, дэд бүтэц хангалттай бүрдсэн бөгөөд үнэлгээний баг болон ТҮБ-ийн төлөөлөл аль аль нь эдгээрийг хялбар ашиглах мэдлэгтэй байх нь үнэлгээг амжилтад хүргэнэ. Итгэмжлэлийн байгууллага алсын үнэлгээ хийхийг шийдвэрлэхээс өмнө эдгээр шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж нягталсан байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 6/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

a) Үнэлгээний үйл ажиллагаанд ашиглахаар тогтоосон технологийг оролцогч талууд хэрэглэх боломж нөөцийг тодорхойлох (Zoom аппликейшн-ийг татаж ашиглахад бэлэн болгох, аппликейшн-ын талаарх мэдлэг, суурин болон зөөврийн компьютерийн хүчин чадал гэх мэт),

b) Оролцогч талуудын интернетэд холбогдох чанарын төвшинг шалгах (Үнэлгээний багт видео бичлэг үзүүлэх болон тухайн хэрэглэгчийн компьютерт алсаас нэвтрэх үед ашиглаж буй төхөөрөмжүүд, интернетийн хурд нөлөөлдөг)

6.1.2 ТҮБ нь алсын зайн үнэлгээ хийх явцад оролцох, нотлох баримт бүрдүүлэхэд шаардлагатай зохих нөөцтэй байна.

6.1.3 Үндэсний итгэмжлэлийн байгууллага алсын зайн үнэлгээ хийхэд ТҮБ-ээс онлайн хурлын програм хангамж худалдан авахыг шаардахгүй бөгөөд тус төв нь Zoom аппликейшн ашиглан үнэлгээг явуулна. ТҮБ нь өөрийн мэдээллийн аюулгүй байдлаас шалтгаалан илүү аюулгүй онлайн шийдэл санал болгож болно. Ийм тохиолдолд үндэсний итгэмжлэлийн байгууллага нөхцөл байдлыг судлан шийдвэр гаргана.

6.1.4 ТҮБ нь үнэлгээний үед шаардлагагүй цаг алдах, үрэхээс сэргийлж алсын зайн үнэлгээнд ашиглах технологитой үнэлгээ хийхээс өмнө бүрэн танилцах, ялангуяа аудио, видео, дэлгэц хуваалцах зэргийг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

6.1.5 ТҮБ нь алсын зайн үнэлгээнд хамрагдах үед ашиглах дэд бүтэц нь дараах шаардлагын хангасан байна. Үүнд:

- Zoom аппликейшн -ын холболт дэмждэг интернет хөтөч ажиллуулах чадвар бүхий нэгээс доошгүй дэлгэцтэй компьютер;
- Хамгийн багадаа 720p -ийн хүчин чадалтай камер;
- Микрофон, чанга яригч эсвэл чихэвч;
- Дүрс дууны тасралтгүй холболтыг хангах тогтвортой интернет холболт;
- Гэрчлэх үйл ажиллагааг шууд дамжуулалт хийхэд шаардлагатай ухаалаг гар утас эсвэл зөөвөрлөх боломжтой камер.

Анхаарах зүйлс:

- Гэрчлэх үнэлгээний үед ТҮБ-ын дүрстэй (видео, онлайн) шууд танилцуулга хийх ур чадвар маш чухал юм. Үүнийг төлөвлөлтийн үе шатанд ярилцах хэрэгтэй. ТҮБ нь шаардлагатай бол камерын суурин байрлалыг тохируулах эсхүл зураг бичлэг хийх тусгай хүн гаргах ёстой.
- Видео төхөөрөмжийн зөөврийн байдал, холболт, батерейны хугацааг анхаарах хэрэгтэй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 7/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

– Шууд видео дамжуулалтыг илүүд үзэх хэрэгтэй. Энэ нь бодит цагийн болон интерактив үнэлгээг өгөх боломжийг олгодог. Мөн урьдчилан хийсэн видео бичлэгт шаардлагатай зураг, өгөгдлийг бүрэн бус өгсөн байх эрсдэлийг бууруулна.

6.2 Боловсон хүчний нөөц

6.2.1 ТҮБ нь үнэлгээний бүхий л үйл явцад бэлэн байх, үнэлгээний багт хөтөч хийх, асуултад хариулах гол ажилтныг урьдчилан томилж, ажиллах нөхцөлөөр хангасан байна.

6.2.2 ТҮБ нь шаардлагатай тохиолдолд техникийн болон захиргааны тодорхой үүрэг бүхий ажилтнуудыг бэлэн байлгана.

6.2.3 Удирдлагын багийн төлөөлөгчид үнэлгээний холбогдох хэсгүүд, нээлт, хаалтын хуралдаанд оролцох боломжтой байна.

6.3 Нууцлал, аюулгүй байдал ба өгөгдлийг хамгаалах

6.3.1 Мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглахад нууцлал, аюулгүй байдал, өгөгдлийг хамгаалах асуудал чухал байдаг. Нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг алсын зайн үнэлгээг эхлүүлэхээс өмнө хоёр тал харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

6.3.2 Нээлтийн хурлын үеэр нууцлалтай холбоотой асуудлыг баталгаажуулсан байна. Үнэлгээний ажлын хэсгийн гишүүд MNAS “Нууцыг задруулахгүй байх амлалт”-ын маягыг бөглөж гарын үсэг зурна.

6.3.3 Үнэлгээний баг болон ТҮБ нь үнэлгээний явцад ямар нэгэн дуу дүрсний бичлэг хийхгүй, зөвшөөрөлгүйгээр хэн нэгний зургийг ашиглахгүй. Гэхдээ энэ нь итгэмжлэлийн үйл ажиллагаанд бодит нотолгоо болон үлдэх шаардлагатай тохиолдолд энэ талаар ТҮБ-д мэдэгдэж, дэлгэцийн баримтжуулалтыг хийж болно.

6.3.4 Итгэмжлэлийн байгууллага болон ТҮБ нь үнэлгээний төлөвлөлтийг хийх явцдаа мэдээлэл, харилцаа холбооны технологийн ашиглалтын талаар тохиролцох хэрэгтэй. Интернет ашиглан дамжуулах мэдээллийн нууцлалыг хангахын тулд шаардлагатай гэж үзсэн баримт, бичиг материал бичлэгийг алсын зайн үнэлгээний хөтөлбөр гаргахаас өмнө авсан байвал зохино.

7. Алсын зайн үнэлгээг гүйцэтгэх

7.1 Ерөнхий зүйл

7.1.1 Алсын зайнаас хийх үнэлгээний үйл явц нь газар дээрх үнэлгээтэй ижил явцтай байна. Энэ нь тухайн ТҮБ итгэмжлэлийн шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа эсэхийг газар дээр нь үнэлэхэд явагддаг үйл явц буюу нээлт, хаалтын хурал, баримт бичгийн, ажилтны ур чадварын нотолгоо, сорилт туршилтын гэрчлэх үйл явц зэрэг бүгдийг багтаасан байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 8/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

7.1.2 Алсын зайн үнэлгээний үргэлжлэх хугацаа нь ТҮБ-ын аль хэсэгт үнэлгээ хийж байгаагаас шалтгаалан газар дээрх үнэлгээтэй харьцуулахад ялгаатай байж болно.

7.1.3 Үнэлгээний баг болон ТҮБ эргэж холбогдох цаг хуваарийг төлөвлөн тохиролцсон тохиолдолд үнэлгээний туршид заавал онлайн холбоотой байхыг шаардахгүй.

7.1.4 Мэдээллийн технологийг ашиглан үнэлгээ хийхдээ хоёр тал хоёулаа дэлгэц хуваалцах, вэб-камерын функцийг ашиглахыг зөвлөж байна. Энэ нь ТҮБ болон үнэлгээний багийн хооронд шилжүүлэх шаардлагатай өгөгдөл, мэдээллийн хэмжээг бууруулдаг. Гэхдээ үнэлгээний ажил нь их хэмжээний мэдээллийн тусламжтайгаар илүү үр дүнтэй хийгддэг тул үнэлгээний баг тайлан бичихэд шаардагдах баримт нотолгоог цахим болон цаасан хэлбэрээр ирүүлэхийг санал болгож болно.

Мөн ТҮБ нь үнэлгээнд шаардлагатай нотлох баримт бичгийг имэйлээр илгээх эсхүл файл хуваалцах, цахим хуудас ашиглан өгөхийг хүсч болно. Мэдээллийн технологи ашиглан нэмэлт байдлаар ирүүлсэн аливаа мэдээллийг нууцлалыг ханган ажиллана.

8. Зайнаас үнэлгээ хийх бэлтгэл ажил

8.1 Алсын зайнаас үнэлгээ хийхээс өмнө Үнэлгээний багийн ахлагч ТҮБ-тэй тохиролцсон ижил медиа платформыг ашиглан уулзалт зохион байгуулж, төлөвлөсний дагуу алсын зайнаас үнэлгээг хийж гүйцэтгэх нөхцөлийг баталгаажуулна.

8.2 Итгэмжлэлийн байгууллагаас шаардсан мэдээллээс гадна Ажлын хэсгийн ахлагч үнэлгээ хийхээс өмнө болон үнэлгээний явцад нэмэлт баримт бичиг, бүртгэл шаардаж болно.

8.3 Багийн ахлагч алсын зайн үнэлгээний төлөвлөсөн хугацааг календарьд (итгэмжлэлийн байгууллагын мэргэжилтэнтэй зөвшилцөж) оруулж, тухайн ТҮБ-ийн нэр оруулсан виртуал өрөөг үүсгэн, холбоо барих холбоос (линк)-ийг ТҮБ-ийн хөтөчид үнэлгээ эхлэхээс таваас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна.

8.4 Багийн ахлагч (итгэмжлэлийн байгууллага)-ийн илгээсэн холбоос дээр дарахад ТҮБ алсын зайн үнэлгээнд холбогдох боломжтой болно. Багийн ахлагчийн даалгасны дагуу итгэмжлэлийн байгууллагын ажилтан нь үнэлгээний багийн гишүүдийг нэг зэрэг үнэлгээг явуулах боломжоор хангаж өөр өөр хэсэг виртуал өрөөнд хуваана.

8.5 ТҮБ нь үнэлгээний багийн гишүүн тус бүртэй виртуал өрөөнд ажиллах техник, технологийн нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Анхаарах зүйл:

– ТҮБ нь хөтөч холбоо барих боломжгүй тохиолдолд нэмэлт мэдээлэл өгөх ажилтны нэр, холбоо барих мэдээллийг (үнэлгээ хийхээс өмнө дээрх бүртгэлийг оруулсан байх) үнэлгээний ажлын хэсгийн ахлагчид ирүүлсэн байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 9/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

9. Алсын зайн үнэлгээ


9.1 Алсын зайнаас хийх үнэлгээ нь газар дээрх үнэлгээтэй ижил бөгөөд Багийн ахлагчийн гаргасан үнэлгээний төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.

9.2 ТҮБ нь шаардлагатай үед дэлгэцийг үнэлгээний багтай хуваалцаж, нотлох баримтыг харуулна. ТҮБ нь үнэлгээний багаас хүссэн нотлох баримтыг имэйл болон бусад хэлбэрээр илгээх бол үнэлгээний багийн ахлагч руу илгээнэ.

Zoom аппликейшн онлайн хэрэгслүүд дээрх үндсэн удирдамжуудыг доор харуулав.

Үүнд үнэлгээний явцад ашиглах дараах үндсэн функцууд орно.

1. Аудиог асаах, унтраах
2. Камерыг асаах, унтраах
3. Оролцогчдын нэрс
4. Мессеж бичих
5. Дэлгэцийг хуваалцах
6. Бичлэг хийх



Зураг 1. Zoom аппликейшн-ын харагдах байдал

9.3 Хэрэв алсын зайнаас хийсэн үнэлгээ нь тогтоосон хугацаанд хангалттай үр дүнд хүрэхгүй нь тодорхой болсон тохиолдолд цаг сунгах талаар холбогдох талууд хэлэлцэн шийдвэрлэнэ.

9.4 Үнэлгээ хийх явцад үнэлгээний баг дотоод хэлэлцүүлэг хийхийн тулд ТҮБ-тэй холбоо таслах шаардлагатай болж магадгүй юм. Энэ тохиолдолд ТҮБ-ийн хамаарал бүхий ажилтнууд виртуал уулзалтын өрөөнд холбоотой байх ёстой.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 10/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

9.5 Алсын зайнаас үнэлгээ хийх явцад илэрсэн үл тохирлыг ердийн журмын дагуу баримтжуулж, хаалтын уулзалтын үеэр тайлбарлаж, танилцуулна. Үл тохирлыг хаах хугацаа нь ердийн журмын дагуу явагдана.

Анхаарах зүйлс:

- a) Хэрэв тухайн үйл явцыг хянах боломжгүй эсхүл тодорхойлох боломжгүй тохиолдолд бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх хэрэгтэй.
- b) Үнэлгээ чимээгүй, аюулгүй орчинд аль болох чимээ гаргахгүй байхаар, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж хийгдэх ёстой.
- c) Цэвэр шуугиангүй харилцаа тогтоохын тулд чихэвч эсхүл дэвшилтэт микрофон ашиглах хэрэгтэй.
- d) Үнэлгээг гүйцэтгэх өрөө нь ердийн үнэлгээний төлөвлөгөө, үйл явцын дагуу байх бөгөөд ТҮБ нь үнэлгээний баг, гишүүдэд орчны мэдээллийг онлайнаар танилцуулна. Мөн үнэлгээний баг хуралдаан, ярилцлага бүрийн эхэнд өрөөнд хэн байгааг тодорхойлохын тулд ТҮБ-ээс өрөөнд байгаа хүмүүсийг харуулахыг хүсэх хэрэгтэй.
- e) Үнэлгээний явцад мэдээлэл харилцаа холбооны технологи, техник хэрэгсэлд тавигдсан шаардлагад нийцэхгүй болсон тохиолдолд үнэлгээний баг үнэлгээг зогсоох хэрэгтэй. Энэ тохиолдолд болон эсхүл интернет холболт тогтвортой биш тохиолдолд итгэмжлэлийн үнэлгээг үргэлжлүүлэхийн тулд утас бусад хэрэгслийг ашиглаж холбоо тогтооно.
- f) Олон хүн оролцсон тохиолдолд оролцогчид хэн ярьж байгааг үргэлж танилцуулж байх болон үнэлгээний туршид сонссон, хэлсэн, уншсан зүйлийг баталгаажуулах хэрэгтэй.
- g) Зайнаас хийсэн үнэлгээг нэгтгэн дүгнэж, тухайн өдрийн үйл явдлын тойм, анхаарал татсан асуудлуудыг тодруулах, үл тохирол, хүлээлт зэргийг дүгнэх хэрэгтэй.
- h) Үнэлгээний баг урьдчилан тохиролцсоны дагуу нууц бичиг баримт, зураг, бичлэг гэх мэтийг устгасныг баталгаажуулах хэрэгтэй.
- i) Итгэмжлэлийн байгууллага үнэлгээний багийн гүйцэтгэл, үнэлгээний үр дүнг хянах арга хэмжээг зохион байгуулж болно.

10. Гэрчлэх үнэлгээний үйл явцын техник ажиллагаа

10.1 Алсын зайны үнэлгээний үед гэрчлэх үйл явцыг зохион байгуулах нь төвөгшил ихтэй хэсэг юм. Хэрэв ТҮБ нь сайн зохион байгуулалттай бол гэрчлэх үйл явцыг шууд дамжуулалт, бичлэг байдлаар эсхүл ярилцлага ашиглан хийж болно.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 11/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		

МОНГОЛЫН УЛСЫН ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО

10.2 Шууд дамжуулалтын хувьд ТҮБ нь алсын зайнаас үнэлгээ хийхийн өмнө тухайн байршил дахь видео болон аудио шууд дамжуулалтыг зөв хийж, Багийн ахлагчийн шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ёстой.

10.3 Бичлэгийн хувьд эдгээрийг Багийн ахлагчтай урьдчилан тохиролцох шаардлагатай. ТҮБ нь бичлэгийг дуу дүрсний чанар хангасан болохыг баталгаажуулна.

10.4 Үйл ажиллагаа эрхэлж буй ажилтнууд юу хийж байгаагаа тод сонсогдохүйц байдлаар тайлбарлан ярина. Энэ үед техникийн ажилтнуудтай ярилцах, асуулт хариулт явуулах боломжтой байх шаардлагатай.

Анхаарах зүйл:

Холболтын асуудал гарсан тохиолдолд:

а) Үнэлгээгээ үргэлжлүүлэхийн тулд ТҮБ-тэй дахин холбогдохыг хичээнэ. Мөн өөр линк өгөх зэргээр дахин холболтод шаардлагатай арга хэмжээг авна.

б) Төлөвлөсөн хугацаанд сэтгэл ханамжтай холболт, нөхцөлийг бүрдүүлэх боломжгүй тохиолдолд үнэлгээний баг хуваариас өмнө үнэлгээг цуцалж болно.

---xxx---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P706	Алсын зайн үнэлгээ хийх журам	
Хэвлэсэн огноо: 01.02.2021	Өөрчлөлт No: 01	Хуудас: 12/12
	Өөрчлөлтийн огноо: 01.02.2021	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ		